



ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

2022 оны 06 дугаар сарын 17
№ 23(1221)

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН АЛБАН МЭДЭЭЛЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
ТАМГЫН ГАЗАР

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
ТАМГЫН ГАЗАР



ГАРЧИГ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

443.	Банкны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай		1707
------	---	--	------

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

444.	Хянан шалгах түр хороо байгуулах тухай	Дугаар 21	1708
445.	Хянан шалгах түр хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай	Дугаар 24	1712
446.	Хуулийн төсөл буцаах тухай	Дугаар 27	1713
447.	Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын гишүүнээр томилох тухай	Дугаар 28	1714
448.	Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүнээр томилох тухай	Дугаар 29	1715

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

449.	Дүрэм батлах тухай	Дугаар 401	1716
450.	Журам батлах тухай	Дугаар 402	1719



ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

2022 оны 06 дугаар сарын 17
№ 23(1221)

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН АЛБАН МЭДЭЭЛЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
ТАМГЫН ГАЗАР

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
ТАМГЫН ГАЗАР



МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2022 оны 06 дугаар
сарын 03-ны өдөр

Улаанбаатар
хот

БАНКНЫ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙГ ДАГАЖ МӨРДӨХ ЖУРМЫН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. 2021 оны 01 дүгээр сарын 29-ний өдөр баталсан Банкны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн “2022” гэснийг “2023” гэж өөрчилсүгэй.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА

Г.ЗАНДАНШАТАР

Хуульчилсан үсэг

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА

2022 оны 06 сарын 03-ны өдөр

Улаанбаатар хот,
МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА
Т. АНДАНШАТАР

6 дүгээр зүйл. 2021 оны 01 дүгээр сарын 29-ний өдөр баталсан Банкны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн “2022” гэснийг “2023” гэж өөрчилсүгэй.

Улаанбаатар хот,
МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА
Т. АНДАНШАТАР



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2022 оны 05 дугаар
сарын 19-ний өдөр

Дугаар 21

Улаанбаатар
хот

Хянан шалгах түр хороо байгуулах тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин наймдугаар зүйлийн 2 дахь хэсэг, Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.1, 33.3 дахь хэсэг, 34 дүгээр зүйлийн 34.2, 34.3 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.2014-2018 оны хооронд хэрэгжүүлсэн “Төрөөс эмийн талаар баримтлах бодлого”-ын хэрэгжилтэд хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлангийн дүнг үндэслэн санаачилсан Улсын Их Хурлын хянан шалгах түр хорооны тусгай шалгалтын сэдвийг “Хүний эмийн чанарын асуудал”-аар байхаар тогтоосугай.

2.Улсын Их Хурлын хянан шалгах түр хорооны тусгай шалгалт нь 2019 оноос 2022 оны 03 дугаар сарыг дуусталх хугацааг хамрах бөгөөд хүрээ хязгаарыг доор дурдсанаар тогтоосугай:

1/хүний эмийн чанар;

2/хуурамч болон стандарт бус эмийн үйлдвэрлэл, нийлүүлэлт.

3.Монгол Улсад эмийн хяналт шалгалтыг сайжруулах, эсхүл хяналт шалгалтын үйл ажиллагааг үр дүнтэй болгох талаарх саналыг Улсын Их Хуралд танилцуулсугай.

4.Улсын Их Хурлын хянан шалгах түр хороог дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай:

Олонхыг төлөөлөн:

П.Анужин

Д.Батлут

Э.Батшугар

М.Оюунчимэг

Ц.Сандаг-Очир

Б.Саранчимэг

Н.Учрал

Ж.Чинбүрэн

Улсын Их Хурлын гишүүн

Улсын Их Хурлын гишүүн

Улсын Их Хурлын гишүүн

Улсын Их Хурлын гишүүн

Улсын Их Хурлын гишүүн

Улсын Их Хурлын гишүүн

Улсын Их Хурлын гишүүн

Улсын Их Хурлын гишүүн



Цөөнхийг төлөөлөн:

Б.Бейсен	Улсын Их Хурлын гишүүн
С.Ганбаатар	Улсын Их Хурлын гишүүн
Т.Доржханд	Улсын Их Хурлын гишүүн
С.Одонтуяа	Улсын Их Хурлын гишүүн
Ц.Туваан	Улсын Их Хурлын гишүүн

5.Улсын Их Хурлаас хугацааг сунгахаас бусад тохиолдолд Улсын Их Хурлын хянан шалгах түр хороо нь энэ тогтоолыг баталсан өдрөөс хойш 6 сарын дотор хяналт шалгалт явуулж тайланг санал, дүгнэлтийн хамт Улсын Их Хуралд танилцуулсугай.

6.Энэ тогтоолыг 2022 оны 05 дугаар сарын 19-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

Г.ЗАНДАНШАТАР

Mongol Folio - 02 Урд Нэгдэл 02 Дооногд

Уулзварын хөдөлгөөнийг зохион байгуулсан өдөр / 2022 оны 05 сарын 19 /

Уулзварын хөдөлгөөнийг зохион байгуулсан өдөр / 2022 оны 05 сарын 19 /

Уулзварын хөдөлгөөнийг зохион байгуулсан өдөр / 2022 оны 05 сарын 19 /

Уулзварын хөдөлгөөнийг зохион байгуулсан өдөр / 2022 оны 05 сарын 19 /

Уулзварын хөдөлгөөнийг зохион байгуулсан өдөр / 2022 оны 05 сарын 19 /



6 | Эцгэр 9 14-р сар тэнгэр ,
7 | Үндэстэн Өдөр 10-р сар тэнгэр Өдөр 11-р сар тэнгэр ..

11 | Үндэстэн Өдөр 11-р сар тэнгэр Өдөр 12-р сар тэнгэр ..
12 | Үндэстэн Өдөр 12-р сар тэнгэр Өдөр 13-р сар тэнгэр ..

13 | Үндэстэн Өдөр 13-р сар тэнгэр Өдөр 14-р сар тэнгэр ..

14 | Үндэстэн Өдөр 14-р сар тэнгэр ..

- 15 | Үндэстэн Өдөр 15-р сар тэнгэр ..
- 16 | Үндэстэн Өдөр 16-р сар тэнгэр ..
- 17 | Үндэстэн Өдөр 17-р сар тэнгэр ..
- 18 | Үндэстэн Өдөр 18-р сар тэнгэр ..
- 19 | Үндэстэн Өдөр 19-р сар тэнгэр ..
- 20 | Үндэстэн Өдөр 20-р сар тэнгэр ..
- 21 | Үндэстэн Өдөр 21-р сар тэнгэр ..
- 22 | Үндэстэн Өдөр 22-р сар тэнгэр ..

23 | Үндэстэн Өдөр 23-р сар тэнгэр ..

24 | Үндэстэн Өдөр 24-р сар тэнгэр ..



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2022 оны 06 дугаар
сарын 02-ны өдөр

Дугаар 27

Улаанбаатар
хот

Хуулийн төсөл буцаах тухай

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.10 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Монгол Улсын Засгийн газраас 2020 оны 05 дугаар сарын 12-ны өдөр Монгол Улсын Их Хуралд Хөрөнгийн үнэлгээний тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн төслийн хамт өргөн мэдүүлсэн Патентын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Шүүхийн шинжилгээний тухай хуульд нэмэлт оруулах тухай, Үл хөдлөх эд хөрөнгийн албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Эрдэнэсийн сангийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийг буцаах нь зүйтэй гэсэн санал, дүгнэлт Байнгын хорооноос гаргасныг нэгдсэн хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн тул хууль санаачлагчид нь буцаасугай.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА

Г.ЗАНДАНШАТАР

Mongol & Folio_02 Укд Ногво да Довдого

ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ ᠶ᠋ᠢᠨ ИХ ХУРЛЫН ДАРГА Г.ЗАНДАНШАТАР

ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ ᠶ᠋ᠢᠨ ИХ ХУРЛЫН ДАРГА

ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ ᠶ᠋ᠢᠨ ИХ ХУРЛЫН ДАРГА Г.ЗАНДАНШАТАР

ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ ᠶ᠋ᠢᠨ ИХ ХУРЛЫН ДАРГА Г.ЗАНДАНШАТАР

ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ ᠶ᠋ᠢᠨ ИХ ХУРЛЫН ДАРГА Г.ЗАНДАНШАТАР

ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ ᠶ᠋ᠢᠨ ИХ ХУРЛЫН ДАРГА Г.ЗАНДАНШАТАР

ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ ᠶ᠋ᠢᠨ ИХ ХУРЛЫН ДАРГА Г.ЗАНДАНШАТАР

ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ ᠶ᠋ᠢᠨ ИХ ХУРЛЫН ДАРГА Г.ЗАНДАНШАТАР



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2022 оны 06 дугаар
сарын 02-ны өдөр

Дугаар 28

Улаанбаатар
хот

Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын гишүүнээр томилох тухай

Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1, 12.5, 12.6 дахь хэсэг, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 108 дугаар зүйлийн 108.2 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын гишүүнээр Сангишаравын Дондовыг томилсугай.

2.Энэ тогтоолыг 2022 оны 06 дугаар сарын 02-ны өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА

Г.ЗАНДАНШАТАР

Монгол Улсын Их Хурлын Төрийн мэдээлэл
Монгол Улсын Их Хурлын Төрийн мэдээлэл

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ
МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ
МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ
МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ
МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ
МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ
МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ
МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ
МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ
МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ
МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ
МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ
МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ
МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2022 оны 06 дугаар
сарын 02-ны өдөр

Дугаар 29

Улаанбаатар
хот

Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүнээр томилох тухай

Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.3, 32.4 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 108 дугаар зүйлийн 108.2 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүнээр Ядамжавын Цэлмэнг томилсугай.

2.Энэ тогтоолыг 2022 оны 06 дугаар сарын 02-ны өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА

Г.ЗАНДАНШАТАР

Mongol Folio_ 02 Ykil Nogeda 0a Docx69x4

ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ-ын ИХ Хурлын Тогтоол - 2022 оны 06 сарын 02 өдөр

ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ-ын ИХ Хурлын Тогтоол
ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ-ын ИХ Хурлын Тогтоол
ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ-ын ИХ Хурлын Тогтоол

ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ-ын

ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ-ын ИХ Хурлын Тогтоол
ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ-ын ИХ Хурлын Тогтоол
ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ-ын ИХ Хурлын Тогтоол
ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ-ын ИХ Хурлын Тогтоол
ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ-ын ИХ Хурлын Тогтоол

ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ-ын ИХ Хурлын Тогтоол
ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ-ын ИХ Хурлын Тогтоол
ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ-ын ИХ Хурлын Тогтоол
ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ-ын ИХ Хурлын Тогтоол
ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ-ын ИХ Хурлын Тогтоол

ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ-ын ИХ Хурлын Тогтоол
ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ-ын ИХ Хурлын Тогтоол
ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ-ын ИХ Хурлын Тогтоол
ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ-ын ИХ Хурлын Тогтоол
ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ-ын ИХ Хурлын Тогтоол

ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ-ын ИХ Хурлын Тогтоол
ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ-ын ИХ Хурлын Тогтоол
ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ-ын ИХ Хурлын Тогтоол
ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ-ын ИХ Хурлын Тогтоол
ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ-ын ИХ Хурлын Тогтоол



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2021 оны 12 дугаар
сарын 31-ний өдөр

Дугаар 401

Улаанбаатар
хот

Дүрэм батлах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ын 79.3-т заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1.“Нутгийн удирдлагын төлөөллийн байгууллагын дүрэм”-ийг хавсралт ёсоор баталсугай.

2.Нутгийн удирдлагын төлөөллийн байгууллагын анхдугаар хуралдааныг 2022 оны эхний хагас жилд багтаан зохион байгуулахыг аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд зөвлөсүгэй.

3.Энэ тогтоолыг 2022 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД**

Л.ОЮУН-ЭРДЭНЭ

**МОНГОЛ УЛСЫН САЙД,
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ
ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА**

Ц.НЯМДОРЖ

Засгийн газрын 2021 оны
401 дүгээр тогтоолын хавсралт

НУТГИЙН УДИРДЛАГЫН ТӨЛӨӨЛЛИЙН БАЙГУУЛЛАГЫН ДҮРЭМ

Нэг.Нийтлэг үндэслэл

1.1.Энэ дүрмийн зорилго нь Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 79 дүгээр зүйлд заасан нутгийн удирдлагын төлөөллийн байгууллага (цаашид “Төлөөллийн байгууллага” гэх)-ын үйл ажиллагааг зохицуулахад оршино.

1.2.Энэ дүрмийг хуралдаан даргалагчаар сонгогдсон эрх бүхий албан тушаалтан хуулийн этгээдийн улсын бүртгэлд бүртгүүлснээр Төлөөллийн байгууллагыг байгуулагдсанд тооцно.

1.3.Төлөөллийн байгууллага нь нийтийн эрх зүйн этгээд байна.



1.4.Төлөөллийн байгууллага нь албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагаандаа албан бичгийн хэвлэмэл хуудас, тамга хэрэглэнэ.

Хоёр.Төлөөллийн байгууллагын гишүүнчлэл

2.1.Аймаг, сум, нийслэл, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал Төлөөллийн байгууллагын гишүүн байна.

2.2.Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал энэ дүрмийн 2.1-д заасан гишүүний эрх, үүргээ Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 79.2-т заасан өөрийн төлөөлөгчөөр дамжуулан хэрэгжүүлнэ.

Гурав.Төлөөллийн байгууллагын чиг үүрэг

3.1.Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 79.1-д зааснаар Төлөөллийн байгууллага нь дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

3.1.1.нутгийн өөрийн удирдлагын байгууллагуудын нийтлэг ашиг сонирхлыг илэрхийлэх;

3.1.2.Засгийн газартай хэлэлцээр хийх;

3.1.3.нутгийн удирдлагын байгууллагын өмнөөс шүүхэд төлөөлөн нэхэмжлэл гаргах.

3.2.Энэ дүрмийн 3.1.2-т заасан чиг үүргийг нутгийн өөрийн удирдлагатай холбоотой хууль тогтоомжийн төсөл болон орон нутгийн төсөв боловсруулах, нутгийн удирдлагад чиг үүрэг шилжүүлэх, Засгийн газраас нутгийн удирдлагатай холбоотой асуудлаар шийдвэр гаргах ажиллагаанд хэрэгжүүлнэ.

Дөрөв.Төлөөллийн байгууллагын үйл ажиллагаа

4.1.Төлөөллийн байгууллагын үйл ажиллагааны үндсэн хэлбэр нь хуралдаан байна.

4.2.Орон нутгийн Хурлын сонгуулийн үр дүнгээр бүх шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурал бүрэн эрхээ хэрэгжүүлж эхэлснээс хойш Төлөөллийн байгууллагын хуралдааныг нэг удаа зарлан хуралдуулах бөгөөд нийт гишүүдийн 50 хувиас доошгүй нь санал гаргасан бол дахин нэг удаа хуралдаан зохион байгуулж болно.

4.3.Төлөөллийн байгууллагын хуралдаанд сум, дүүрэг бүрээс тус бүр нэг төлөөлөгч, аймаг, нийслэлээс тус бүр хоёр төлөөлөгч тухайн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгчдөөс сонгогдон оролцох ба тухайн Хурлаас баталж өгсөн удирдамжид заасан байр суурийг баримтална.



4.4.Энэ дүрмийн 4.2-т заасан хуралдаанд нийслэлийн нэг төлөөлөгч, 5 дүүргийн төлөөлөгч, нийт аймаг болон сумын төлөөлөгчийн 50-аас доошгүй хувь нь оролцсон бол хүчинтэйд тооцно.

4.5.Төлөөллийн байгууллагын хуралдааныг тухайн хуралдаанаас нэр дэвшүүлэн, сонгосон хуралдаан даргалагч удирдана.

4.6.Төлөөллийн байгууллагын хуралдаанаас гарах аливаа шийдвэрийг дийлэнх олонхын саналаар батална.

4.7.Төлөөллийн байгууллага нь ажлын албатай байх бөгөөд ажлын албаны чиг үүргийг Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ажлын алба хариуцан гүйцэтгэнэ.

4.8.Төлөөллийн байгууллагын хуралдаанд оролцох төлөөлөгч хэлэлцэх асуудал санаачлах эрхтэй бөгөөд тухайн төлөөлөгчийн санаачилсан асуудлыг нийт сумын төлөөлөгчдийн гуравны нэг, нийт аймгийн төлөөлөгчдийн гуравны нэг, нийт дүүргийн төлөөлөгчдийн гуравны нэг, нийслэлийн нэг төлөөлөгч хамтран дэмжсэн бол хуралдааны хэлэлцэх асуудалд оруулна.

4.9.Энэ дүрмийн 4.8-д заасан хэлэлцэх асуудалтай холбоотой шийдвэрийн төсөл, холбогдох тооцоо, судалгааг уг асуудлыг дэмжсэн төлөөлөгчид хамтран боловсруулж, бэлтгэнэ.

4.10.Төлөөллийн байгууллага нь өөрийн үйл ажиллагаанд шаардагдах зардлыг гишүүний татвар хэлбэрээр бүрдүүлсэн хөрөнгөөр санхүүжүүлж болно.

Тав.Засгийн газартай харилцах

5.1.Төлөөллийн байгууллагын хуралдаанаас гарсан шийдвэрийн талаар Засгийн газартай харилцахад Төлөөллийн байгууллагыг тухайн хуралдааныг даргалагч төлөөлнө. Хуралдаан даргалагчийн эрх Төлөөллийн байгууллагын дараагийн хуралдааныг зарласнаар дуусгавар болно.

5.2.Энэ дүрмийн 5.1-д заасан Төлөөллийн байгууллагын төлөөлөгч хуралдаанаас гарсан шийдвэрийг өөрийн гарын үсэг, Төлөөллийн байгууллагын тамгаар албажуулан Засгийн газарт хүргүүлэх бөгөөд шаардлагатай тохиолдолд Засгийн газрын төлөөлөлтэй биечлэн уулзаж, шийдвэрийн талаар нэмэлт тайлбар, холбогдох мэдээлэл гаргаж өгөх эрхтэй.

5.3.Засгийн газар Төлөөллийн байгууллагын шийдвэрийн талаар үндэслэл бүхий хариу хүргүүлэх ба Засгийн газрын шийдвэр гаргах ажиллагаанд харгалзан үзнэ.

---ооо---

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2021 оны 12 дугаар
сарын 31-ний өдөр

Дугаар 402

Улаанбаатар
хот

Журам батлах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ын 44.2-т заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1.“Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгчийн үйл ажиллагаа, тэдгээрийг чадавхжуулах арга хэмжээний зардлын нийтлэг жишиг, зарцуулах, тайлагнах журам”-ыг хавсралт ёсоор баталсугай.

2.Энэ тогтоолыг 2022 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД**

Л.ОЮУН-ЭРДЭНЭ

**МОНГОЛ УЛСЫН САЙД,
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ
ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА**

Ц.НЯМДОРЖ

Засгийн газрын 2021 оны
402 дугаар тогтоолын хавсралт

ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТӨЛӨӨЛӨГЧИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА, ТЭДГЭЭРИЙГ ЧАДАВХЖУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ЗАРДЛЫН НИЙТЛЭГ ЖИШИГ, ЗАРЦУУЛАХ, ТАЙЛАГНАХ ЖУРАМ

Нэг.Нийтлэг зүйл

1.1.Аймаг, сум, нийслэл, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал (цаашид “Хурал” гэх)-ын төлөөлөгчийн хуулиар олгосон эрх, үүргийн хүрээнд хэрэгжүүлэх үйл ажиллагаа, тэдгээрийг чадавхжуулах арга хэмжээний зардлыг төлөвлөх, санхүүжүүлэх, зарцуулах, тайлагнах, түүнд хяналт тавихтай холбогдсон харилцааг энэ журмаар зохицуулна.

1.2.Хурлын болон төлөөлөгчийн тухайн жилд хэрэгжүүлэх үйл ажиллагаа, тэдгээрийг чадавхжуулах арга хэмжээг Хурлын байгууллагын стратеги, тухайн жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд, зардлыг Хурлын тухайн жилийн төсвийн төсөлд тусгаж, зардлыг санхүүжүүлэх болон

зарцуулах, тайлагнах үйл ажиллагаанд хяналт тавих ажлыг тухайн шатны Хурлын төсвийг захиран зарцуулах эрх бүхий төсөв захирагч хэрэгжүүлнэ.

1.3.Төлөөлөгчийн үйл ажиллагаа, тэдгээрийг чадавхжуулах арга хэмжээний зардлыг энэ журамд зааснаас өөр зориулалтаар зарцуулахыг хориглоно.

Хоёр.Төлөөлөгчийн үйл ажиллагааны зардлыг төлөвлөх, санхүүжүүлэх

2.1.Төлөөлөгч нь Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 39 дүгээр зүйлд заасан эрх, үүргийн хүрээнд холбогдох үйл ажиллагааг хэрэгжүүлж ажиллана.

2.2.Төлөөлөгчийн үйл ажиллагаанд шаардагдах зардлыг тухайн орон нутгийн эдийн засаг, үйлдвэрлэл, нийгмийн хөгжил, хүн амын тоо, газар зүйн байршил, ажлын цар хэмжээ зэргийг харгалзан тогтооно.

2.3.Төлөөлөгчийн үйл ажиллагааны зардал нь төлөөлөгчийн хуулиар хүлээсэн чиг үүргээ хэрэгжүүлэх зардал, сонгогчдын дунд зохион байгуулах арга хэмжээнд шаардлагатай заал, танхимын түрээсийн зардал болон шуудан, холбоо, бичиг хэрэг, албан томилолт зэрэг урсгал зардал, урамшууллын зардлаас бүрдэнэ.

2.4.Төлөөлөгчийн сарын урамшууллын зардлыг Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгчид хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 3 дахин, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгчид хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 2 дахин, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгчид хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 2 дахин, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгчид хөдөлмөрийн хөлсний доод хэмжээтэй тэнцүү хэмжээтэй байхаар тооцон олгож болно.

2.5.Төлөөлөгчийн үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд шаардагдах тээврийн болон бусад зардлыг санхүүжүүлэхдээ санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний баталсан эдийн засгийн ангиллын дагуу тухайн Хурлын байгууллагын төсөвт зардлын хүрээнд тооцон төлөвлөж, хэрэгжүүлнэ.

Гурав.Төлөөлөгчийг чадавхжуулах арга хэмжээний зардлыг төлөвлөх, санхүүжүүлэх

3.1.Төлөөлөгчийг чадавхжуулах арга хэмжээ гэж төлөөлөгч хуулиар хүлээсэн чиг үүргээ хэрэгжүүлэх, Хурлын үйл ажиллагаанд төлөөлөгчийн оролцоог нэмэгдүүлэх, харилцаа холбоо, мэдээллийн



технологийн болон хууль, эрх зүйн орчны талаар шаардлагатай мэдлэг, ур чадварын түвшинг ахиулахад чиглэсэн үйл ажиллагааг ойлгоно.

3.2.Төлөөлөгчийг дараах байдлаар чадавхжуулах бөгөөд түүнд шаардагдах зардлыг төлөвлөн санхүүжүүлнэ:

3.2.1.зорилтот сургалт;

3.2.2.чиглүүлэх сургалт;

3.2.3.богино хугацааны түргэвчилсэн сургалт;

3.2.4.цахим болон зайны сургалт;

3.2.5.төлөөлөгчдийн хяналт хийх сургалт;

3.2.6.гадаад улсын болон дотоодын туршлага судлах сургалт.

3.3.Төлөөлөгчдөд зориулсан чадавхжуулах арга хэмжээг тухайн орон нутгийн онцлог, цаг үеийн нөхцөл байдлыг үнэлэн, хууль тогтоомжид заасан чиг үүргийн хүрээнд тухайн шатны Хурлын ажлын албанаас хариуцан зохион байгуулна.

3.4.Тухайн шатны Хурлын дарга болон Хурлын Зөвлөлийн санаачилгаар төлөөлөгчийг гадаад улсад болон дотоодод туршлага судлах сургалтад хамруулж болно.

3.5.Төлөөлөгчийг чадавхжуулах арга хэмжээг Засгийн газрын харьяа төрийн албаны сургалтын байгууллага болон холбогдох сургалтын чиглэлээр мэргэшсэн сургалтын бусад байгууллага, судлаачдын багтай хамтран зохион байгуулна.

3.6.Чадавхжуулах арга хэмжээний хүрээнд албан томилолтын зардлыг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний баталсан зардлын жишгээр тооцож олгоно.

3.7.Төлөөлөгчийн үйл ажиллагаа, чадавхжуулах арга хэмжээнд шаардагдах зардлын төсвийг сар, улирлаар хуваарилах бөгөөд урьд олгогдсон төсвийн гүйцэтгэлийн санхүүгийн баримт, тайланг бүрэн гаргасны дараа төлөөлөгчийн бичгээр ирүүлсэн хүсэлтийг үндэслэн дараагийн сар, улирлын төсөвт зардлыг тухай бүр олгоно.

3.8.Төлөөлөгчийн зардлыг бэлнээр олгохгүй бөгөөд үнийн нэхэмжлэх болон бусад баримтыг үндэслэн зардлын хязгаарт багтаан холбогдох санхүүжилтийг тухайн байгууллагад шилжүүлнэ.



Дөрөв.Төлөөлөгчийн үйл ажиллагааны болон чадавхжуулах арга хэмжээний зардлыг тайлагнах, түүнд хяналт тавих

4.1.Төлөөлөгч нь үйл ажиллагааныхаа төсвийн зарцуулалтын тайлан, холбогдох санхүүгийн баримтыг зохих хууль тогтоомжийн дагуу үнэн зөв бүрдүүлж, тогтоосон журмын дагуу Хурлын ажлын албанд тухай бүр гаргаж өгнө.

4.2.Ажлын алба тухайн төлөөлөгчийн төсвийн гүйцэтгэлийг гаргахдаа хэтрэлт, хэмнэлтийг зардлын зүйл, анги тус бүрээр тооцон мэдээлэх арга хэмжээг авна.

4.3.Төлөөлөгч үйл ажиллагааны зардлаа хэтрүүлсэн тохиолдолд илүү зарцуулсан зардлыг тухайн төлөөлөгч өөрөө хариуцах буюу дараагийн сар, улирлын зардлаас хасаж тооцно.

4.4.Төлөөлөгч үйл ажиллагаа зохион байгуулахдаа зардлыг хэмнэсэн бол зарцуулаагүй үлдэгдлийг, эсхүл тодорхой шалтгаан, нөхцөлийн улмаас үйл ажиллагааг хэрэгжүүлэх боломжгүй болсон тохиолдолд зардлын санхүүжилтийг тус тус ажлын 5 хоногийн дотор Хурлын байгууллагын дансанд буцаан төлнө.

4.5.Ажлын алба нь төлөөлөгчийн зардлын гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу улирал, жилийн төсвийн гүйцэтгэлийн тайланд тусган, нягтлан бодох бүртгэлийн журмын дагуу тооцоо нийлж, аудитын байгууллагаар хянуулж, дүгнэлт гаргуулна.

4.6.Ажлын алба төлөөлөгчдийн үйл ажиллагааны болон чадавхжуулах арга хэмжээний зардлын тайланг нэгтгэж, дүнг Зөвлөлийн хуралд танилцуулах бөгөөд шаардлагатай гэж үзвэл Хурлын нэгдсэн хуралдаанд танилцуулж болно.

Тав.Бусад

5.1.Энэ журмыг зөрчсөн төлөөлөгч, бусад албан тушаалтанд Төсвийн тухай хууль, Төрийн албаны тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжид заасан хариуцлага хүлээлгэнэ.

---oOo---



Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгчийн үйл ажиллагаа, тэдгээрийг чадавхжуулах арга хэмжээний зардлын нийтлэг жишиг, зарцуулах, тайлагнах журмын хавсралт

**ТӨЛӨӨЛӨГЧИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА, ТЭДГЭЭРИЙГ ЧАДАВХЖУУЛАХ
АРГА ХЭМЖЭЭНИЙ ЗАРДЛЫН НИЙТЛЭГ ЖИШИГ**

№	Зардлын зориулалт	Зардлын жишиг (жилээр)
1.	Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгч	15.0 сая төгрөг хүртэл
2.	Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгч	5.0 сая төгрөг хүртэл
3.	Дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгч	3.0 сая төгрөг хүртэл
4.	Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгч	1.0 сая төгрөг хүртэл

Тайлбар: Зардлын нийтлэг жишигт төлөөлөгчид олгох урамшууллыг нэмж тооцно.



Хаяг:

“Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн редакц,
Улаанбаатар-14201, Төрийн ордон 124 тоот
И-мэйл: turiin_medeel@parliament.mn

Утас: 262420

Хэвлэлийн хуудас: 1.25

Индекс: 200003